

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ОРЧИН

Илтгэгч: Б.Ариунсан –УТЕГ-ын дэд дарга

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих анхны алхамуудыг хийж эхэлсэн 1990-ээд оноос Монгол улсын өмнө тулгарсан томоохон зорилгын нэг нь зах зээлийн эдийн засагт нийцсэн орчин үеийн татварын тогтолцоог цоо шинээр бүрдүүлэн бий болгох явдал байв.

Дээрхи зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сүүлийн жилүүдэд олон улсын нийтлэг жишигт нийцсэн татварын тогтолцоог бий болгон улмаар улс, орон нутгийн төсвийг орлогын тогтвортой эх үүсвэрээр хангах, дотоодын үйлдвэрлэл болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын суурийг өргөжүүлэн татварын дарамтыг багасгах, дэлхийн нийтийн жишигт нийцсэн татварын албыг бий болгох, олон улсын банк, санхүү эдийн засгийн байгууллагуудын санал зөвлөмж харилцан тохиролцсон эдийн засгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан бодлогыг дэс дараатай хэрэгжүүлэв.

Үүний үр дүнд өнөөдөр Монгол улсын татварын тогтолцооны эрх зүйн орчин бүрдэж, олон улсын нийтлэг жишгийн дагуу орлого, хэрэглээ болон хөрөнгөд татвар ногдуулдаг боллоо.

Энэ дагуу Монгол улсын үндэсний татварын тогтолцооны өнөөгийн байдлын талаар та бүхэнд товч мэдээлье.

1. Татварын түвшин

Дэлхийн банкнаас хийсэн судалгаанаас үзэхэд ДНБ-д татварын нийт орлогын эзлэх хэмжээ дунджаар ОУХАХБ-ын гишүүн орнуудад 36.0 орчим хувь, Азийн орнуудад 14.0 %, Ойрхи Дорнодын орнуудад 11.0 %, Төв, Зүүн Европ болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудад 23.0 % тус тус байгаа бөгөөд энэ үзүүлэлт манай улсад 1999-2005 онд 19.59 –аас 31.0 % болж өсжээ.

Хэдийгээр хөгжиж буй орнуудын дундаж үзүүлэлтээс манай улсын татварын түвшин их байгаа боловч эдийн засаг, нийгмийн хөгжил, тулгарч буй бэрхшээлийн хувьд адил төстэй Зүүн Европын болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан зарим улсуудтай ойролцоо түвшинд байна. /график-1,2,3/

Манай улсад татварын түвшин хөгжиж буй орнуудын үзүүлэлтээс их байгааг эдгээр орнуудад боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах болон нийгмийн хамгааллын асуудалд Засгийн газраас зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээ харилцан адилгүй байдагтай холбож авч үзэж болох юм.

Нөгөө талаар ДНБ харьцангуй тогтвортой тохиолдолд татварын орлогын хэмжээ нэмэгдэж, татварын түвшин өсч болох үндсэн хоёр хүчин зүйл байдгийг дурдах нь зүйтэй. Үүнд тухайлбал татварын хувь хэмжээг

нэмэх, хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах зэргээр эрх зүйн зохицуулалтын хүрээнд тодорхой арга хэмжээ авах, хоёрдугаарт татвар хураалтын үйл ажиллагааг сайжруулж татварын орлогыг нэмэгдүүлэх асуудал хамаардаг. Сүүлийн жилүүдэд татвар хураалтыг сайжруулах талаар Үндэсний татварын албанаас нэлээд арга хэмжээ авч үр дүнд хүрч байна.

Тухайлбал 2005 он гэхэд ҮТА-аас төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээ 2000 онтой харьцуулахад 2 гаруй дахин өслөө.

2. Татварын бүтэц

Монгол улсын татварын бүтцийг гадаад орнуудын татварын бүтэцтэй харьцуулж үзэхэд гол гол татварын нэр төрлийн хувьд адил байгаа боловч дотоодын бараа үйлчилгээний татварын татварын нийт орлогод эзлэх хэмжээ харьцангуй өндөр, гадаад худалдааны болон хөрөнгийн татварын эзлэх хэмжээ бага байна.

Гол гол татварын орлогын нийт татварын орлогод эзлэх хэмжээ бусад орныхоос нэлээд ялгаатай буюу их байдаг нь бусад орнууд татварын нийт орлогоо үндсэн 9 төрлийн татвараас бүрдүүлж байхад манай улсад 6 төрлийн татвараас бүрдүүлж байгаатай холбоотой юм. /график-4,5/

Тухайлбал, хөгжиж буй орнуудад нийт татварын орлогын 20-30 орчим хувийг импорт, экспортын татварын болон хөрөнгийн татварын орлогоор бүрдүүлж байхад манай улсын хувьд энэ төрлийн татвараар орлогын тун бага хувь буюу 8 орчим хувийг бүрдүүлж байна.

Энэ байдал нь манай улсад зарим татварын хувь хэмжээ өндөр байгаад нөлөөлж байгааг тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

Судалгаанаас үзэхэд Монгол улсын татварын тогтолцоо хэдийгээр зарим тоон үзүүлэлтийн хувьд бусад орныхоос ялгаатай байгаа боловч татварын нэр төрөл, тэдгээрийн нийт татварын орлогод эзлэх хувь хэмжээний өөрчлөлтийн чиг хандлагын хувьд адил төстэй, олон улсын нийтлэг жишигт нийцсэн орчин үеийн татварын тогтолцоо бий болох үндэс суурь тавигдсан гэж дүгнэж байна.

3. Татварын эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал

Бизнесийн таатай орчинг бүрдүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх зорилгоор татварын ачааллыг бууруулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгаж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг адил тэгш урамшуулах, бага орлоготой иргэдийн татварын ачааллыг багасган орлогыг нь нэмэгдүүлэх, татварын албаны үйл ажиллагааг татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэхэд түлхүү хандуулах чиглэлээр сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газар дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлж ирлээ.

Тухайлбал 2000-2003 онд Аж ахуйн нэгж, байгууллагын болон хүн амын орлогын албан татварын дээд хувь 40 байсныг 30 % болгон бууруулах, зарим зардлыг татвар ногдох орлогоос хасч тооцдог болох, аж ахуйн нэгж, байгууллагын зар сурталчилгааны зардал, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлыг татвар ногдуулах орлогоос хасагдах хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх, олон улсын тусламжийн байгууллагын шугамаар импортоор орж ирж байгаа хариу төлбөргүй илгээсэн бараа болон буяны байгууллагаас өгсөн санхүүжилт /мөнгөн хөрөнгөөр/-ээр дотоодын зах зээлээс худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж байх, Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, угсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизм импортоор оруулахад нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, Хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу жилийн албан татвараас 36000 төгрөгийн татварыг хөнгөлдөг байсныг 48000 төгрөг болгож 12000 төгрөгөөр нэмэгдүүлэх, Монгол улсад байнга оршин суух татвар төлөгчийн хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого, зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлогыг 2003 оны 1 дүгээр сарын 1 хүртэл албан татвараас чөлөөлж байсныг 2005 оны 1 дүгээр сарын 1-нийг хүртэл чөлөөлөхөөр сунгах, хүн амд олгож байгаа нийгмийн хамгааллын шинж чанартай тэтгэмж, нөхөн олговор, төлбөрийг татвараас чөлөөлөх нь зүйтэй гэж үзэж «Хуульд заасны дагуу олгож байгаа тэтгэмж, нөхөн олговор, төлбөр»-ийг татвар ногдох орлогоос хасч тооцож байх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж ирлээ.

Түүнчилэн Монгол улсын Засгийн газар Улсын Их Хурлын 2005 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг үндэс болгон татварын харилцааны эрх зүйн зохицуулалтыг иж бүрэн судалж, татварын суурийг өргөтгөх, татвар тэгш, шударга байх зарчмыг хэрэгжүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, салбараар ялгаварласан аливаа хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах, татварын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр татварын багц хуульд өөрчлөлт оруулж, татварын шинэтгэл хийх төслөө 2005 онд өргөн барьсан юм.

Татварын шинэтгэлийн зорилтууд нь дараахь асуудлуудыг хамарч байна. Үүнд:

1. Ажлын байр шинээр бий болгож, бизнес эрхлэгчдэд ногдох татварын ачааллыг бууруулах замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

2. Ажиллах хүчинд ногдох татварын дарамтыг багасгах замаар ажиллах хүчний зардлыг бууруулж Монгол улсын эдийн засгийн цар хүрээг өргөжүүлэх

3. Татварын ачааллыг бууруулах, татварын албаны үйл ажиллагааг боловсронгуй болгох замаар далд эдийн засгийг ил болгох
4. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн ялгавартай байдлыг арилгаж, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих
5. Татварын албаны үйл ажиллагааг ил тод, хөнгөн шуурхай болгох, татвар төлөгчдөд үзүлэх үйлчилгээг өргөжүүлэх .

Монгол улсын Засгийн газраас өргөн барьсан хуулиудын төслийг Улсын Их Хурал 2006 оны Хаврын Чуулганаараа авч хэлэлцэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Онцгой албан татварын хуулиудыг шинэчлэн найруулж батлаад байна.

Эдгээр батлагдсан хуулиудаар дараахь зарчмын шинжтэй асуудлуудыг шийдвэрлэв. Үүнд:

Нэгдүгээрт, бизнесийн таатай орчинг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг татварын хувь хэмжээг бууруулах чиглэлээр томоохон алхам хийгдлээ.

Шинээр батлагдсан хуулийн дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дээд, доод хувийг хэмжээг тус бүр 5 пунктээр бууруулж, албан татвар ногдуулах орлогын шатлалын доод хэмжээ 100.0 сая төгрөг байсныг 3.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүллээ.

Мөн хүн амын орлогын албан татварын одоогийн мөрдөгдөж байгаа 10, 20, 30 гэсэн хувь хэмжээг 10 хувь болгон өөрчилж, шатлалгүй болгосны зэрэгцээ нэмэгдсэн өртгийн татварын хувь хэмжээг 5 пунктээр бууруулан 10 % болгов.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээ 15 % байсныг 10 % болгож бууруулсан нь эдийн засагт хэрэглээний зардлыг бууруулах эерэг үр дүн авч ирэх юм.

Эдгээр гурван төрлийн татварын хувьд Монгол улс олон улсын хэмжээнд хамгийн бага татвартай орон болж, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжсэн, өмнөхөөс илүү тааламжтай урьдчилсан нөхцлийг бүрдүүллээ.

Тухайлбал, жилийн 3.0 тэрбум төгрөг хүртэлх ашигтай аж ахуйн нэгж 10 хувиар орлогын албан татвар төлөх бөгөөд энэ нь тухайн төрлийн татвар төлөгч нийт аж ахуйн нэгжийн 99,9 хувь болж байгаа бол хувь хүний цалин, хөдөлмөрийн хөлс, аж ахуйн үйл ажиллагааны орлогын хэмжээнээс үл хамаарч татвар нь 10 хувь байх юм.

Эдгээр хувь хэмжээ нь Азийн бусад орнуудтай харьцуулахад нэлээд бага хувь хэмжээ болж байна. /график 6, 7, 8/ Ингэснээр өөрсдөө ажиллан өөрөө бүтээх, бодох, сэтгэх, бүтээх, амьдрах эрмэлзэлийг хөгжүүлэн дэмжсэн шинэчлэл боллоо гэж үзэж байна.

Уул уурхайн салбарын хувьд зарим экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн огцом өсөлт, аж ахуйн нэгжийн болон хүн амын орлогын албан татварын хэмжээг бууруулж байгаа зэргийг харгалзан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон «Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль»-ийг УИХ-аас шинээр батлаад байна.

Энэ хууль нь алт, зэсийн хүдэр болон баяжмалын дэлхийн зах зээлийн үнэ, суурь үнийн зөрүүд, тухайлбал 1 унци алтны үнэ 500 америк доллараас дээш, 1 тонн зэсийн хүдэр болон баяжмалын үнэ 2600 америк доллараас дээш хэсэгт татвар ногдуулах асуудлыг зохицуулж байгаа бөгөөд Үндэсний татварын албаны хувьд уг хуулийг татвар төлөгчдөд аль болох хүндрэл, бэрхшээл учруулахгүйгээр хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Одоо мөрдөж байгаа «Ашигт малтмалын тухай хууль»-д ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүх бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувь, шороон ордоос олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан алтны хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь борлуулалтын үнэлгээний 7,5 хувьтай тэнцүү байгаа бол шинэчлэн найруулж баталсан хуулиар дотоодод борлуулж байгаа эрчим хүчний зориулалтаар ашиглах нүүрс, түгээмэл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувь, эдгээрээс бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувьтай тэнцүү байх юм.

Хоёрдугаарт, татварын хуулиудад оруулсан зарчмын нэг өөрчлөлт нь татварын ачааллыг бууруулах үндсэн дээр татварын элдэв, хөнгөлөлт, чөлөөлөлтийг хүчингүй болгон татварын суурийг өргөжүүлэх, татварын тэгш шударга зарчмын хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Энэ зорилгоор одоогийн мөрдөж буй хуулиудаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад татварын ялгавартай хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж байсныг хүчингүй болгож, тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулж байгаа хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт үзүүлэх, тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон зарим салбарт тусгайлсан хуулиудаар үзүүлж байсан нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг хүчингүй болгохоор боллоо.

Гуравдугаарт, аж ахуйн нэгжийн болон хүн амын орлогын албан татварын хувьд албан татвар ногдох орлогоос хасагдах зардлын нэр төрлийг нэмэгдүүлэх, зарим хязгаарлалтыг багасгах замаар татварын ачааллыг бууруулах арга хэмжээ авлаа.

Жишээ нь татвар ногдох орлогоос хасагдах зардалд зар сурталчилгааны зардал, сургалтын зардал, ажиллагсдад олгосон шагнал, урамшуулал, байр, орон сууцны хөлсний болон унаа, хоол, байр түлшний үнийн хөнгөлөлт, сайн дурын даатгалын хураамж, бараа материалын хэвийн хорогдол зэрэг зарим гол зардлуудыг шинээр нэмж оруулан татвар төлөх ашгийн хэмжээг нь багасгаж өгөх асуудлыг шийдвэрлэсэн болно.

Дөрөвдүгээрт, дотоодын үйлдвэрлэл болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох нөхцлийг бүрдүүлэх, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн заалтууд хуульд тусгагдлаа.

Шинээр байгуулагдан үйл ажилдага явуулж эхэлсэн аж ахуйн нэгж эхний жилдээ алдагдалтай ажиллавал татварын тайлангаар гарсан алдагдлыг дараагийн 2 жилд шилжүүлэн, татвар ногдуулах орлогоос нь хасч хөнгөлөлт үзүүлэхээр болов.

Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн татварын хөнгөлөлтийн хэмжээ 48000 төгрөг байсныг 84000 төгрөг болгон нэмэгдүүлэхээр хууль батлагдлаа.

Энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь ахуйн нэгжүүд ажиллагсдын цалингаа нэмэгдүүлэх, хувь хүмүүс сайн дурын үндсэн дээр орлого, татвараа үнэн зөв тодорхойлж, татвараа төлдөг болох, улмаар иргэд хуримтлалтай болох чухал ач холбогдолтой болно.

Мөн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн үйлдвэрлэж бэлтгэсэн, үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн түүхий эд "мах, сүү, өндөг, арьс шир, үр тариа"-ны дотоодын үйлдвэрлэгчдэд нийлүүлсэн үнэд нэмэгдсэн өртгийн албан татварын 10 хувь шингэсэн гэж үзэн, уг түүхий эдийг худалдан авч үйлдвэрлэл явуулж буй дотоодын үйлдвэрлэгч өөрийн төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцож байхаар шийдвэрлэв.

Эдгээр хуулиуд батлагдсанаар төсвийн орлого жил бүр дунджаар 160.0 орчим тэрбум төгрөгөөр буурах бөгөөд энэ орлого аж ахуйн нэгж хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, иргэд хуримтлалтай болоход зарцуулагдана гэсэн үг юм.

Анхаарал тавьсанд баярлалаа.

The Mongolian Tax System: Leading the Way

By: B.Ariunsan, Deputy Director General
General Department of National Taxation

Mongolia began the transition to a market economy in 1990. Over the past 15 years, one of the major objectives of the government has been to create a tax system that was not only compatible with a market economy but also one that increased the dynamism and creativity of the Mongolian market economy.

To achieve this objective, particularly in recent years we have considered and implemented recommendations relating to the tax system from a wide range of organizations including international banking, aid and business organizations. The policies we implemented were aimed at creating a tax system that was able to provide a sustainable source of revenue for the government, that would spread the cost of taxes equitably across individuals and businesses, that would increase Mongolia's competitiveness by promoting domestic and foreign investment, that would expand the tax base by reducing wasteful tax holidays and the size of the shadow economy and thus enable tax rates to be reduced, and, one that would reflect international best practices.

As a result of the government's efforts, a stable legal framework has been created for the tax system in Mongolia. The taxes that are imposed on a wide range of tax bases such as income, consumption and property are consistent with international best practices.

In this context, I would like to briefly describe the major features of the current national tax system of Mongolia.

1. Total tax revenue

A World Bank study has found that in the countries of the Organization for Economic Cooperation and Development (OECD) total tax revenues are on average about 36 percent of GDP; in Asian countries taxes are about 14.0 percent of GDP; in the Middle-Eastern countries they are 11.0 percent of GDP, and in the Central and Eastern European countries and the former Soviet republics tax revenues are on average 23.0 percent of GDP.

In Mongolia, taxes as a percentage of GDP have increased from 19.6 percent in 1999 to 31.0 percent in 2005. Thus, although the tax level in our country is higher than the average level in developing countries, it is comparable with countries of the Eastern Europe and former Soviet Union that are facing similar economic and social development challenges (Graphs 1, 2, and 3).

The fact that the tax level is higher in our country than in many other developing countries can be explained by the differing amounts of

government funds being expended on education, culture, science, health care, and social welfare in these countries.

It is also worth mentioning that there are two principal factors that can lead to an increase in tax revenue as a percent of GDP. First, tax rates might be increased or the tax base broadened. Second, tax revenues might increase due to improved tax administration and tax collections. In recent years, the National Tax Authority (NTA) has taken several measures to improve tax administration and collections. For instance, the amount of tax revenue transferred to the budget by NTA in 2005 more than doubled compared with the amount in 2000 even though the tax rates and tax base did not undergo major changes.

2. The tax mix

The taxes that Mongolia relies upon most heavily in raising revenues is similar to those relied upon in other countries. However, the share of domestic goods and services taxes in total tax revenue is relatively higher in Mongolia than other countries and the share of foreign trade and property taxes is relatively lower.

One reason that the share of the principal types of taxes in total tax revenue is different in Mongolia than other countries is because most countries have 9 principal types of taxes generating total tax revenues whereas Mongolia has only six (Graphs 4 and 5).

For instance, import, export, and property taxes generate about 20-30 percent of total tax revenues in most developing countries. However, such taxes generate only about 8 percent of total tax revenue in our country. Thus tax rates on other tax bases have had to be somewhat higher in Mongolia.

Nevertheless, although some studies have shown that the tax mix differs somewhat in Mongolia than that in other countries, the types of taxes and trends of changes in shares of those taxes in total tax revenue are similar and the foundations for creating a modern tax system that meets international standards have been established, particularly following the recent reforms in Mongolia.

3. Rationalizing the legal framework for the tax system

From 2000 to 2004, the Government of Mongolia embarked on a gradual process of tax reform in order to reduce tax burdens, minimize tax credits and exemptions, place domestic and foreign investors on an equal footing, assist low-income citizens, and direct more resources of the tax administration to the provision of services for taxpayers in order to create a favorable business environment and promote production, services, and investment activities.

For example, over that period the Government took the following actions:

- To reduce the top rates of corporate income tax and personal income tax from 40 to 30 percent in the years 2000-2003;
- To ensure the deductibility of all legitimate business expenses from taxable income;
- To double the deductibility of advertising and employee training and retraining business expenses from taxable income;
- To exempt domestic goods, work, and services that are purchased by using finances (in cash) and imported goods provided by international assistance program and charities from VAT;
- To exempt equipments and heavy machineries imported and used by foreign invested business entities for purpose of investment in priority sectors and export production from VAT;
- To increase annual tax credit by MNT 12,000 from MNT 36,000 to MNT 48,000 in the Personal Income Tax Law;

4. *Going Forward with Fundamental Tax Reform*

In 2004, concerned that the pace of tax and economic reform was too slow, the Mongolian government adopted a four-year action plan. The Action Plan included “creating at least 145,000 new jobs by providing sustainable macroeconomic development and establishing a favorable environment for business and investment into infrastructure development.” It also called for “reducing the burden of taxes and fees on employers, supporting industries with broad employment opportunities” and “implementing a flexible tax policy tied to incomes and livelihood level of Mongolian households.”

In 2005 the government launched an ambitious tax reform process based on the “Guidelines for Improving Legislation of Mongolia Toward 2008.” It presented a draft document on tax reforms to Parliament in 2005.

The objectives of the tax reforms included the following goals:

1. Increase country competitiveness by lowering the tax burden on businesses, enabling job creation
2. Reduce labor cost and expand the scope of the economy of Mongolia by minimizing tax burdens on wage earners;
3. Expose the shadow economy by reducing tax burdens and improving tax administration;
4. Support domestic investors by removing discriminatory tax provisions;
5. Simplify tax administration procedures to reduce compliance costs and arbitrariness, by focusing more on service to tax payers

The Government presented draft legislation to the Parliament of Mongolia in the spring session of 2006. The proposed reforms were thoroughly debated both in Parliament and in public forums. As a result, newly drafted Corporate Income Tax Law, Personal Income Tax Law, Value-added Tax Law, and the Excise Tax Law were approved by the Parliament in June 2006.

These reforms address the following issues of principle:

First, in order to create a favorable tax framework, major steps have been taken in reducing tax rates. The basic tax rate in Mongolia is now 10 percent.

The top and low corporate income tax rates were reduced by 5 percentage points in the newly approved law and the income threshold for the low rate was increased from MNT 100.0 million to MNT 3.0 billion. Hence, the tax rate on corporate profits up to MNT 3.0 billion is only 10 percent and it is only 25 percent on annual profits over that amount.

In addition, the current progressive rates of personal income tax - 10, 20, and 30 percent – have been converted into a flat 10 percent rate.

The VAT rate is reduced from 15 to 10 percent, which will reduce the cost of consumption for Mongolian families.

In terms of these three taxes, Mongolia now has the lowest rates of tax. These rates will provide strong incentives for the promotion of production and investment. For instance, a business entity that makes a profit up to MNT 3.0 billion a year will pay income tax at the rate of 10 percent. This accounts for 99.9 percent of all taxpayer business entities. Salaries and wages of individuals and income from proprietorship activities will be subject to 10 percent tax regardless of the amount.

These rates are relatively low compared even with those of other Asian countries (Graphs 6, 7, and 8). Therefore, we believe that the reforms will provide the conditions for innovation, dynamism and creativity in Mongolia.

Given these reductions in the rates of corporate and personal income tax, and given the rapid increases in the prices of some of Mongolia's exports in the world market, the Parliament of Mongolia recently approved a Windfall Profits Tax on some products processed in the mining industry.

This law imposes a tax on the marginal prices of gold and copper ore and concentrate when they exceed a certain base price; for instance, on a portion of 1 ounce of gold whose price exceeds USD 500 and on that of 1 ton of copper ore and concentrate whose price exceeds USD 2,600. The NTA enforces this law with as few constraints as possible on taxpayers.

Under the newly drafted and approved law, whereas there is a royalty equal to 2.5 percent of the sales value of all products extracted from a given mining concession and sold and shipped for sale or utilized, and the royalty for gold extracted from a placer and sold and shipped for sale or utilized is 7.5 percent of the sales value under the current Law on Mineral Resources, the royalty for coal and common minerals to be used for energy sold domestically is only 2.5 percent of the sales value of the products extracted from a given mining concession and sold and shipped for sale or utilized. The royalty for minerals other than the ones mentioned above is 5.0 percent of the sales

value of the products extracted from a given mining concession and sold and shipped for sale or utilized.

Second, several fundamental amendments were made to the tax laws by repealing various targeted tax credits and exemptions and broadening the tax base. Also, the tax concessions that remain are simple and widely available. Thus, the principle of a fair, simple and equal tax system is implemented.

For these purposes, it was decided to repeal the tax credits and exemptions that discriminated between foreign and domestic investors; provide an investment tax credit equal to 10 percent of investments in new plant and equipment in various priority sectors and industries; and, repeal several VAT credits and exemptions including those for priority sectors and industries.

Third, the tax laws have been amended to ensure that businesses can generally deduct all of their costs incurred in earning income. For example, some primary costs including those of promotion and training, awards and incentives for employees, and allowances for housing, transport, lodging, boarding, and fuel, voluntary insurance fees, and normal depreciation of inventories and intangibles are included in costs deductible from taxable income.

Fourth, new provisions for the promotion of domestic production and for small and medium enterprises in order to establish a framework for creation of jobs are incorporated into the laws. As well, the new laws will increase the discretionary income of citizens.

If a newly formed business entity suffers losses in the first year of its start-up, it can now carry forward these losses to the following two years and deduct them from taxable income.

The law has increased the annual individual tax credit from Tg 48,000 to Tg 84,000 in order to increase the discretionary income of citizens.

These actions should allow business entities to increase the salaries of their employees and individuals to accurately determine their income and taxes and accumulate savings over time.

Moreover, it is decided that since 10 percent of VAT is included in prices at which raw materials for animal husbandry and agricultural production like 'meat, milk, eggs, skins and hides, and crops' produced by citizens and business entities by themselves operating in animal husbandry and agriculture but not made in primary industrial processing are supplied to domestic producers, the domestic producers that purchase these raw materials and run production operations can deduct this amount from VAT they pay with a view to promoting domestic production.

These new tax laws will result in a loss of government budget revenues of about MNT 160 billion annually. This implies that this additional revenue will be available to businesses to increase their investments in Mongolian enterprises and be available to individual Mongolians to increase their standard of living.

Thank you for your attention.